

БАТЛАВ  
САНГИЙН САЙД  
Б.ЖАВХЛАН

БАТЛАВ  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД  
Х.НЯМБААТАР

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

Хууль зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.32 дахь заалтад ““Нийгмийн даатгалын сангийн төсөв” гэж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн дагуу бурдүүлж, зарцуулах, тухайн жилд Улсын Их Хурлаас баталсан төсвийг” гэж, 10 дугаар зүйлийн 10.1.3 дахь заалтад “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, мөн хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.9 дэх заалтад “Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг жил бүрийн намрын эзлжит чуулганаар хэлэлцэн 11 дүгээр сарын 15-ны дотор батлах” гэж тус тус заасан нь Нийгмийн даатгалын сангийн 2024 төсвийн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Практик шаардлага

Монгол Улсын Засгийн газар Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд эдийн засгийн өсөлтийг эрчимжүүлэх, төлбөрийн тэнцлийн алдагдлыг бууруулах, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, үнийн өсөлтийг хязгаарлаж иргэдийн бодит орлогыг хамгаалах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад чиглэсэн бодлого, арга хэмжээг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тодотголоор тэтгэврийн зөрүүг арилгаж, өндөр настны болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлсэн нь 2023 онд иргэдийн бодит орлого өсөхөд нелөөлсөн.

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Нийгмийн даатгалын багц хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Тус хуулийн шинэчлэлээр нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг санхүүгийн эргэлтэд оруулах, ахмадын орлогыг хамгаалах зорилгоор тэтгэврийг дундаж цалингийн өөрчлөлт, инфляцын түвшинтэй уялдан жил бүр тогтмол нэмэгдүүлэх,

тэтгэврийн зөрүү арилгах итгэлцүүр хэрэглэх, даатгуулагчдад үзүүлэх тэтгэвэр, тэтгэмжийн хүртээмжийг сайжруулах, залуу малчдыг дэмжиж нийгмийн даатгалын сангийн өгөөжийг нэмэгдүүлэх бодлогыг тодорхойлсон. Ингэснээр нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг жил бүр үнийн өсөлттэй уялдуулан нэмэгдүүлж байх тогтолцоо бүрдэж байна.

Энэхүү бодлогын өөрчлөлтийн дагуу Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсөвт тэтгэвэр бодох дараалсан 7 жилийг 5 жил болгон бууруулах, 2023 оны төсвийн тодотголын хэрэгжилтийг хангах, тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлэх, малчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн 50 хувийг улсын төсвээс хамтран төлөх зэрэг арга хэмжээтэй холбоотой зардлыг нэмэгдүүлэх шаардлага үүсэж байна.

Түүнчлэн тэрийн албан хаагчдын цалин хөлс болон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэх арга хэмжээ, аж ахуй нэгж, байгууллагад ажиллагсдын дундаж цалин хөлсний өөрчлөлттэй уялдуулан нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлого өсөх тул сангийн эх үүсвэрийг нэмэгдүүлэн батлах шаардлагатай байна.

**Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл 2 бүлэг, 6 зүйлтэй байх бөгөөд доор дурдсан агуулгатай байна.  
Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн нийтлэг үндэслэл, зорилт, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль тогтоомжийн тухай;

Хоёрдугаар бүлэгт Нийгмийн даатгалын санд 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн төвлөрүүлэх орлогын хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн зарцуулах төсвийн эрх хэмжээ, Нийгмийн даатгалын сангийн төсөвт 2024 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагчийн эргэн төлөх төлбөрийн тухай болон хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тусгана.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх арга хэмжээний талаар**

Хуулийн төсөл батлагдсанаар Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчиний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу 2024 оны төсвийн жилд нийгмийн даатгалын сангийн эх үүсвэр бий

болгож хуrimтлуулах, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжид зориулан хөрөнгө зарцуулах эрх зүйн орчин бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн төслийн талаар**

Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль тогтоомжид бүрэн нийцнэ. Хуулийн төсөлтэй холбогдуулан шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн төсөл байхгүй болно.

---oOo---